



М.ЦЭНД

*Оросын Холбооны Улсын Дотоод
явдлын яамны Москвагийн их сургуулийн
адъюнкт, хурандаа*

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ҮҮСГЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар “Эрүүгийн хэрэг үүсгэх” ажиллагаа бол байцаан шийтгэх ажиллагааг эхлэн явуулах гарцаагүй, хууль ёсны үндэслэлийг хангалттай тогтоох эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бие даасан шат билээ.

ЭБШ эрх зүйн онолоор энэ шатны зорилтыг мөрдөн байцаалтын ажиллагаагаар бус, эрх зүйн өвөрмөц шинжтэй аргыг хэрэглэн шийддэг гэж үздэг ч тэрхүү өвөрмөц арга өөрөө процессын зарим ажиллагаа байдаг. Эрүүгийн хэрэг үүсгэх гарцаагүй үндэслэлийг хангалттай тогтоох, үндэслэл бүхний аль нэгэн шийдвэрийг гаргах, тухайн мөчид үйлдэж байгаа гэмт үйлдлийг таслан зогсоох, үйлдэхээр бэлтгэж, завдаж буй гэмт хэргийг урьдчилан сэргийлэх арга хэмжээ гагцхүү хууль ёсны ажиллагаанд үндэслэх ёстой.

Эрүүгийн хэрэг үүсгэх бодит үндэслэлийг тогтоовол эрүүгийн хэрэг үүсгэх (ЭБШХ-ийн 172.1.1); эс тогтоовол эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргах, татгалзах (172.1.2); гомдол, мэдээллийг шалгуулахаар харьяаллын дагуу шилжүүлэх (172.1.3) гэсэн шийдвэрийн аль нэгийг гаргаж, энэ тухай гомдол, мэдээлэл гаргагчид мэдэгдэхээр хуульд заасан. Ийм шийдвэрийг гаргахын тулд тэдгээрийг “нотлох” зайлшгүй шаардлагатай ч манай Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 80 дугаар зүйлд түүнийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны үед л хэрэгжүүлэхээр заасан нь учир дутагдалтай.

Доктор Ж. Болдбаатар: хуулийн дээрхи заалтаас “...эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны эхний шат буюу эрүүгийн хэрэг үүсгэх үед нотолгоо явагддаггүй гэж үзэхээр байна” гэж дүгнэсэн нь энэ шатанд нотлох ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж өгөх зайлшгүй шаардлагатай болохыг илтгэж байна⁵⁵.

⁵⁵ Ж. Болдбаатар. Эрүүгийн хэрэг үүсгэх шатан дахь нотолгооны онцлог. “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2004 он. № 4. 22 дахь тал.

Энэ шат эрүүгийн хэрэг үүсгэх шалтгаан тодорхой болсон цагаас эхлэх бөгөөд тийм үндэслэл бий эсэхийг тодорхойлж өгсөн шийдвэр гаргаснаар төгсдөг.

Доктор Ж.Болдбаатар “Эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагаа нь эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл бий болоход эхлэн, энэ талаар гарсан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болоход дуусна” гэж тодорхойлжээ. Эрүүгийн хэрэг үүсгэх шатны хамгийн гол онцлог нь эрүүгийн хэрэг үүсгээгүй байгаа үед байцаан шийтгэх зарим арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх шаардлага тулгардагт оршино.

Манай ЭБШХ-ийн 166.1-д зааснаар эрүүгийн хэрэг үүсгэх “үндэслэл” нь:

1. Гэмт хэрэг үйлдэгдснийг хангалттай нотлох баримт байх,
2. Байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй нөхцөл байдал үүсээгүй байх явдал юм.

Харин мөн зүйлийн 1.1-ээс 1.5-д заасан:

- гэмт хэрэг гарсан талаар иргэн гомдол гаргасан буюу мэдээлсэн;
- гэмт хэрэг гарсан талаар аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан мэдээлсэн;
- гэмт хэрэг үйлдсэн хэмээн өөрийгөө илчилж ирсэн;
- хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор гэмт хэргийн шинж тэмдгийг өөрсдөө шууд илрүүлсэн;
- гэмт хэргийн талаар гүйцэтгэх ажлын шугамаар авагдаж, баримтжуулагдсан мэдээ баримт байгаа зэрэг нь эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл биш, зөвхөн шалтгаан юм. ОХУ-н Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 140 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт “эрүүгийн хэрэг үүсгэх шалтгаан ба үндэслэл” гэсэн ойлголтуудыг тус тусад нь тодорхойлж өгсөн байдаг. Өөрөөр хэлбэл, энэ таван шалтгааны аль нэг нь тодорхой болмогц дээрх үндэслэл байгаа эсэхийг тогтоох ажиллагааг хэрэгжүүлж эхлэнэ, аль нэг шалтгаан хараахан мэдэгдээгүй байгаа бол ийм ажиллагааг хийж болохгүй гэсэн үг.

Доктор Б.Бат-Эрдэнэ “...эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагаа нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа шинээр бий болох хууль зүйн факт бий болдог⁵⁶” гэж тодорхойлжээ. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн харилцаа үүсснээр эрх бүхий субъектуудад мөрдөн байцаалтын шаардлагатай ажиллагааг хийх, таслан сэргийлэх арга хэмжээ авах эрх нээгддэг.

56 Б. Бат-Эрдэнэ. Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Тусгай анги. УБ. 1999. 3 дахь тал.

ЭБШХ-ийн 126 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “хойшлуулшгүй тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө үзлэг хийж болно” гэж заасан ба 172 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт дараах хойшлуулшгүй ажиллагааг хэрэгжүүлж болохыг заажээ. Үүнд:

172.3.1. хүний нэр хаягийг тодруулах зорилгоор баримт бичгийг үзэж шалгах;

172.3.2. хүний бие, тээврийн хэрэгсэл, ачаа тээшид үзлэг хийх;

172.3.3. аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эд зүйл, эд хөрөнгө, мөнгө агуулсан байр савыг битүүмжлэх;

172.3.4. хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгслийг саатуулах, эд зүйл, мөнгийг түр хугацаагаар хурааж авах;

172.3.5. шүүх эмгэлэг, криминалистикийн болон бусад шинжилгээнд зориулж дээж, хурууны хээ, ул мөрний хэв авах;

172.3.6. иргэн, албан тушаалтнаас тайлбар авах, шаардлагатай тохиолдолд шинжээч томилж, дүгнэлт гаргуулах;

172.3.7. нутаг дэвсгэр, орон байранд нэвтрэн орох, гарахад хяналт тогтоох;

172.3.8. гэмт хэргийг таслан зогсоох, гэмт этгээдийг мөрдөх үед байгууллага, иргэний орон байранд нэвтрэн орох;

172.3.9. согтууруулах ундаа, мансууруулах, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах зэрэг болно. Эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл, шалтгаан тодорхой болмогц түүний бодитой эсэхийг процессын зарим ажиллагааг хэрэгжүүлж нотлох шаардлагатай болдог.

“Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэлд хойшлуулшгүй ажиллагаа явуулах журам”⁵⁷-д зааснаар: “...ЭБШХ-ийн 172 дугаар зүйлийн 172.3.2-оос 172.3.6 дахь хэсэгт заасан ажиллагаануудыг явуулахдаа тэмдэглэл үйлдэх ба тэмдэглэлийг мөн хуулийн холбогдох зүйлүүдэд заасан журмын дагуу үйлдэнэ”. Түүнчлэн, ЭБШХ-ийн 38 дугаар зүйлийн 3-д: “Энэ хуулийн 172.3-т заасан хойшлуулшгүй ажиллагаа явуулж эхэлсэн... үеэс эхлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох эрхтэй” гэж зааж өгсөн. Энэ заалт мөн л уг шатанд ЭБШ ажиллагаа явуулж болохыг хууль зөвшөөрснийг харуулж байна.

Процессын зарим ажиллагааг хэрэгжүүлж, гэмт хэрэг мөн эсэх тухай нотлосноор эрүүгийн хэрэг үүсгэх үү, татгалзах уу гэдэг асуудлыг шийдэх боломж энэ шатанд гарч ирнэ. Ийм шийдвэрийг түргэн хугацаанд гаргах шаардлагатай бөгөөд ингэснээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хууль ёсны эрх ашгийг шуурхай хамгаалж чадна. ОХУ-ын ЭБШХ энэ хугацааг 3 хоног, шаардлагатай тохиолдолд 10 хоног хүртэл сунгахаар заасан⁵⁸ бол манай ЭБШХ-н 171-р зүйлийн 2 дахь хэсэгт 5 ба 14 хоногоор тогтооон байна.

57 Улсын ерөнхий прокурорын 2008 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 123 тоот тушаал “Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэлд хойшлуулшгүй ажиллагаа явуулах журам”

58 ОХУ-ын ЭБШХ-ийн 144.1 ба 144.3-р зүйлүүд

Практикаас харахад эрүүгийн хэрэг үүсгэх шатанд процессын ажиллагаа хийж болохгүй гэсэн ойлголт нилээд байдаг бөгөөд эрүүгийн хэрэг үүсгэх шалтгаан нь ЭБШ ажиллагааг хэрэгжүүлж эхлэх үндэс болно гэдгийг дутуу ойлгодог.

Эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл байгаа эсэхийг тогтоохоор явуулах процессын ажиллагаа нь хууль ёсны ажиллагаа мөн. Тиймээс байцаан шийтгэх ажиллагаагаар эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл тогтоогдохгүй байсан ч энэ нь үндэслэлгүй болохыг албан ёсоор тогтоож өгч буй баримт юм. Харин манайд одоо хэрэгжиж буй практик үүнийг үгүйсгэж, эрүүгийн хэрэг үүсгэх бодит шалтгаан илэрхий байхад “эрүүгийн хэрэг үүсгээгүй” хэмээн байцаан шийтгэх ажиллагаа явуулахыг хориглосоор байна.